



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2023.03.25 № 1/216

танай _____-ны № _____-т

Г **БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ** Г
ДАРГА Ж.ХАТАНБААТАР ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд тус сумын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд баталгаажуулах аудит хийж, аудитын тайлан, дүгнэлт, төлбөрийн акт, албан шаардлагыг хүргүүлж байна.

Аудитаар өгсөн албан шаардлагыг тогтоосон хугацаанд нь зөвлөмжийн биелэлтийг 2023 оны 07 дугаар сарын 30-ны дотор холбогдох нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

Хавсралт.....хуудас.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

005030401

D- alban bichig 2023 A5 TOOT

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Овоо сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2023/9/НА-СТА-ТТЗ

| | |
|--|---|
| Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2023.03.25 | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Ж.Өсөхбаяр Утас: 99890393 Цахим хаяг: Usukhbayarj@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn |
|--|---|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

| | |
|--|-------------------------------------|
| 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ | 3 |
| 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ | 5 |
| 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА | 13 |
| 3.4.1 Мөнгөн хөрөнгө | 14 |
| 3.5.2 Авлага | 14 |
| 3.5.4 Бараа материал | 15 |
| 3.5.6 Үндсэн хөрөнгө | 16 |
| 3.5.7 Өр төлбөр | 17 |
| 3.5.10 Засгийн газрын хувь оролцоо | 17 |
| 3.5.11 Орлогын данс | 17 |
| 3.5.12 Зардлын данс | 18 |
| 4. АУДИТЫН ТАЙЛАН | 21 |
| 4.1 Ерөнхий зүйл | 21 |
| 4.2 Материаллаг байдал..... | 22 |
| 4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт | 22 |
| 4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал..... | 22 |
| 4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт | 22 |
| 4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт..... | 23 |
| 4.7.1 Завсрын аудитын талаар..... | 23 |
| 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ | 23 |
| 5.1 Зөвлөмж..... | Error! Bookmark not defined. |
| 5.2 Албан шаардлага..... | 24 |
| 5.3 Зөвлөмж..... | 25 |
| 5. Хавсралт 1.: Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт | 26 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн хурал |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2023.03.25 № 2/135

танай _____ -ны № _____ -т

Г **Хязгаарлалттай дүгнэлт** Г

Г БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГА Г
Ж.ХАТАНБААТАР ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Баян-Овоо сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Баян-Овоо сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Тус аудитаар болон харьяа төсөвт байгууллагуудын аудитаар илэрсэн зөрчил нь төлөвлөлтийн шатанд урьдчилан тогтоосон материаллаг байдлаас хэтэрсэн бөгөөд бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Малын тоо толгойн албан татварын орлогоор тайлант онд 90,843.3 мянган төгрөг төвлөрсөн байхад орон нутгийн хөгжлийн санд 107,000.0 мянган төгрөг буюу орон нутгийн орлогоос 16,156.7 мянган төгрөг илүү хуваарилсан;
- Тус сумын сум хөгжүүлэх сангаас зээл авсан 10 зээлдэгчийн 58090.6 мянган төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн ч хууль хяналтын байгууллагад шилжүүлээгүй;
- Баян-Овоо сумын "Байгалийн музей болон орон нутаг судлах танхимын барилга"-ын 298,420.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлыг гүйцэтгүүлэхдээ сумын Засаг дарга нь худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй "Гэгээн шавь" ХХК-тай шууд гэрээ байгуулан байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 150,000.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон;
- Тус сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс тайлант онд нийт 65945.0 мянган төгрөгийг зарцуулсан ч зарцуулалтын тайлан, захирамжийн хэрэгжилтийг Засаг даргын зөвлөлд тайлагнаагүй зэрэг зөрчлүүд илэрлээ.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", 41.2.7 дахь "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх

005020535

үр дүнг хангаж ажиллах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана", гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Тайлант онд төсвийн шинэчлэлтэй холбоотойгоор ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн санхүүгийн тайлан Боловсролын ерөнхий газарт, эрүүл мэндийн төвийн тайлан Эрүүл мэндийн яаманд, соёлын төвийн тайлан Соёлын яаманд нэгтгэгдэж, тайланд 5,138,078.2 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын дүгнэлтийн үндэслэл болгосон дээрх зөрчил дутагдал нь бидний урьдчилан тогтоосон материаллаг байдлаас хэтэрсэн, аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалтыг ажил гүйлгээний хувьд хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоо олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Баян-Овоо сумын Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 2022 оны биелэлтийг 88.8 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Баян-Овоо сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Сумын Засаг дарга санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн нэгтгэсэн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ,
АУДИТОР



Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|--------------|---|--------------------|--------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 524,409.2 | 861,250.6 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 114,405.2 | 326,834.2 |
| 31200 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 114,405.2 | 326,834.2 |
| 31210 | Төгрөг | 114,405.2 | 326,834.2 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 114,405.2 | 326,834.2 |
| 33 | АВЛАГА | 224,073.5 | 261,212.3 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 14.9 | 3,115.3 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 110,710.0 | - |
| 33500 | Бусад авлага | 34,140.0 | 100,006.4 |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 250.0 | 66,116.4 |
| 33520 | Хувь хүмүүсээс авах авлага | 33,890.0 | 33,890.0 |
| 33600 | Зээлийн авлага | 79,208.6 | 158,090.6 |
| 33610 | Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага | 79,208.6 | 158,090.6 |
| 33612 | Хувь хүмүүст олгосон зээл | 79,208.6 | 158,090.6 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 175,930.6 | 263,204.1 |
| 35100 | Түүхий эд материал | 52,361.6 | 4,897.2 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 32,813.4 | 4,897.2 |
| 35130 | Эм боох материал | 19,548.2 | - |
| 35200 | Дуусаагүй үйлдвэрлэл | - | 150,000.0 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 123.0 | - |
| 35400 | Хангамжийн материал | 123,445.9 | 108,306.9 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 7,052.3 | 2,615.1 |
| 35420 | Аж ахуйн материал | 49,479.6 | 72,158.5 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 1,005.0 | 10,815.2 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 3,053.1 | 1,747.3 |
| 35450 | Барилгын засварын материал | 1,411.5 | 1,005.5 |
| 35460 | Хүнсний материал | 2,486.6 | 345.0 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 58,957.9 | 19,620.3 |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | 10,000.0 | 10,000.0 |
| 36600 | Бусад нөөц | 10,000.0 | 10,000.0 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 5,789,319.8 | 1,744,292.3 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 5,789,319.8 | 1,744,292.3 |
| 39200 | Биет хөрөнгө | 5,679,624.1 | 1,615,424.3 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 5,657,367.3 | 1,413,871.9 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (938,628.3) | (327,767.2) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 485,654.8 | 398,963.8 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (203,794.7) | (163,094.3) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 722,907.4 | 330,315.2 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (365,614.8) | (207,202.6) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 284,578.9 | 72,299.8 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (112,275.1) | (47,755.9) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 228,302.6 | 240,876.4 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (96,903.8) | (100,882.7) |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 5,800.0 | 5,800.0 |
| 39217 | Ном | 12,229.8 | - |

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|--------------|--|--------------------|--------------------|
| 39300 | Биет бус хөрөнгө | 109,695.7 | 128,868.0 |
| 39301 | Програм хангамж | 3,950.0 | 780.0 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,482.3) | (390.0) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 107,228.0 | 128,478.0 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 6,313,729.0 | 2,605,543.0 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 39,892.5 | 80,063.7 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 39,892.5 | 80,063.7 |
| 41300 | Өглөг | 39,892.5 | 80,063.7 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 3.0 | - |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 34,289.1 | 360.0 |
| 41360 | Бусад өглөг | 5,600.4 | 79,703.7 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 5,600.4 | 79,101.9 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | 601.8 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 6,273,836.5 | 2,525,479.3 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 6,273,836.5 | 2,525,479.3 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 1,368,520.2 | 530,810.9 |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 1,368,520.2 | 530,810.9 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 3,674,480.0 | 1,694,822.1 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,202,112.6 | 5,349,225.0 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 2,472,367.4 | (3,654,402.9) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,230,836.2 | 299,846.3 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 6,313,729.0 | 2,605,543.0 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|-------------|--|--------------------|--------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 5,046,195.5 | 2,493,235.0 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 136,401.1 | 1,905,958.5 |
| 110 | Орлогын албан татвар | 29,522.9 | 1,118,144.0 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 29,522.9 | 1,118,144.0 |
| 110001 | Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх | - | 991,899.8 |
| 110002 | Үйл ажиллагааны орлого | 19,410.7 | 120,736.6 |
| 110003 | Хөрөнгийн орлого | 8,112.2 | 5,427.6 |
| 110004 | Хөрөнгө борлуулсны орлого | 2,000.0 | 80.0 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 720.0 | 116,798.7 |
| 113001 | Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар | - | 25,295.3 |
| 113002 | Бууны албан татвар | 720.0 | 660.0 |
| 113004 | Малд ногдуулах албан татвар | - | 90,843.4 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 106,158.2 | 671,015.8 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 13,180.8 | 7,045.8 |
| 118001 | Улсын тэмдэгтийн хураамж | 1,520.8 | 1,425.8 |
| 118006 | Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | 5,000.0 | - |
| 118009 | Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 6,660.0 | 5,620.0 |
| 1181 | Газрын төлбөр | 6,465.3 | 16,170.5 |
| 118101 | Газрын төлбөр | 6,465.3 | 16,170.5 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 81,907.2 | 647,798.8 |
| 118202 | Ан амьтны нөөц ашигласны төлбөр | 81,907.2 | 647,798.8 |
| 1183 | Бусад татвар | 4,604.9 | 0.7 |
| 118301 | Бусад татвар | 4,604.9 | 0.7 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 2,807,690.9 | 322,255.3 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 2,807,690.9 | 322,255.3 |
| 120003 | Торгуулийн орлого | 16,083.0 | 26,789.8 |

Баян-Овоо сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---------------|--|--------------------|--------------------|
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 55,444.3 | 291,815.9 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 55,000.0 | 149,565.0 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 444.3 | 620.0 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | - | 141,630.9 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 2,623,231.8 | 3,500.0 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 112,931.8 | 149.6 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2,102,103.6 | 265,021.2 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,073,732.1 | 18,363.0 |
| 131003 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 18,363.0 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,073,732.1 | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 312,436.9 | 72,324.4 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 93,068.1 | 52,089.6 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 10,483.8 | 20,234.8 |
| 131107 | Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого | 208,885.0 | - |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 691,981.1 | 174,333.8 |
| 132006 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/ | 600,804.7 | - |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 91,176.4 | 174,333.8 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 23,953.5 | - |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 23,953.5 | - |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 2,522,789.6 | 1,953,650.7 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,522,789.6 | 1,953,650.7 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,471,589.6 | 1,328,658.9 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,118,913.5 | 323,565.1 |
| 210101 | Үндсэн цалин | 891,624.0 | 323,565.1 |
| 210102 | Нэмэгдэл | 154,136.5 | - |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,435.7 | - |
| 210104 | Урамшуулал | 68,717.3 | - |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 145,748.6 | 40,389.9 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 103,871.8 | 27,568.1 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 11,394.7 | 3,391.2 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 9,070.6 | 2,595.6 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,922.8 | 646.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 19,488.8 | 6,189.0 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 267,805.1 | 45,852.4 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 29,433.9 | 9,016.8 |
| 210302 | Түлш, халаалт | 238,261.2 | 36,835.7 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 110.0 | - |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 116,534.2 | 76,956.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 15,767.2 | 7,587.6 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 60,399.4 | 40,463.9 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,287.8 | 733.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 19,896.2 | 10,070.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 11,627.1 | 18,101.5 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 3,556.5 | - |
| 2105 | Нормативт зардал | 159,786.1 | - |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 75,996.3 | - |
| 210502 | Хоол, хүнс | 71,844.5 | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 11,945.4 | - |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 51,825.3 | - |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 831.0 | - |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 44,171.0 | - |
| 210604 | Урсгал засвар | 6,823.3 | - |
| 2107 | Томилолт, зочны зардал | 6,507.0 | 8,089.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,507.0 | 8,089.0 |

Баян-Овоо сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|-------------|---|--------------------|----------------------|
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 203,864.7 | 597,265.1 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 197,776.7 | 590,370.7 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,300.0 | 500.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 590.0 | 810.5 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 492.1 | 655.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 204.6 | 793.9 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,272.9 | 3,564.0 |
| 210807 | Газрын төлбөр | 228.4 | 571.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 400,605.2 | 236,541.4 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 104,138.5 | 48,556.2 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,458.9 | 10,257.0 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 294,007.8 | 177,728.2 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 51,200.0 | 624,991.8 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 37,511.7 | 20,201.0 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | - | 18,601.0 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 14,292.6 | - |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 18,903.0 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,316.0 | 1,600.0 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 509.3 | 363,433.6 |
| 213401 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага | - | 362,071.6 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 509.3 | 1,362.0 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 13,179.1 | 241,357.2 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 13,179.1 | - |
| 213505 | Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт | - | 241,357.2 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 2,523,405.9 | 539,584.4 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 51,038.4 | 4,193,987.3 |
| 225001 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | 51,038.4 | 5,651.5 |
| 225010 | Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө | - | 4,064,687.6 |
| 225011 | Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал | - | 123,648.1 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | 2,472,367.4 | (3,654,402.9) |

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|---|---------------------------------|-----------------------|-------------------|---|
| 1 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,368,520.2 | 1,242,273.6 | 1,190,675.2 | 3,801,469.0 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 11,437.4 | 11,437.4 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,368,520.2 | 1,242,273.6 | 1,202,112.6 | 3,812,906.4 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | - | (11,437.4) | - | (11,437.4) |
| 9 | Тайлант үеийн үр дүн | - | - | 2,472,367.4 | 2,472,367.4 |
| 10 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,368,520.2 | 1,230,836.2 | 3,674,480.0 | 6,273,836.5 |
| 11 | 2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 1,368,520.2 | 1,230,836.2 | 3,674,480.0 | 6,273,836.5 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | (837,709.4) | (929,261.5) | 1,674,744.9 | (92,225.9) |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 530,810.9 | 301,574.7 | 5,349,225.0 | 6,181,610.6 |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | - | (1,728.4) | - | (1,728.4) |
| 19 | Тайлант үеийн үр дүн | - | - | (3,654,402.9) | (3,654,402.9) |
| 20 | 2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 530,810.9 | 299,846.3 | 1,694,822.1 | 2,525,479.3 |

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

| | | /мянган төгрөгөөр/ | |
|---------------|--|--------------------|--------------------|
| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 2,280,938.2 | 2,369,322.5 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 136,401.1 | 1,905,958.5 |
| 110 | Орлогын албан татвар | 29,522.9 | 1,118,144.0 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 29,522.9 | 1,118,144.0 |
| 110001 | Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх | - | 991,899.8 |
| 110002 | Үйл ажиллагааны орлого | 19,410.7 | 120,736.6 |
| 110003 | Хөрөнгийн орлого | 8,112.2 | 5,427.6 |
| 110004 | Хөрөнгө борлуулсны орлого | 2,000.0 | 80.0 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 720.0 | 116,798.7 |
| 113001 | Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар | - | 25,295.3 |
| 113002 | Бууны албан татвар | 720.0 | 660.0 |
| 113004 | Малд ногдуулах албан татвар | - | 90,843.4 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 106,158.2 | 671,015.8 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 13,180.8 | 7,045.8 |
| 118001 | Улсын тэмдэгтийн хураамж | 1,520.8 | 1,425.8 |
| 118006 | Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | 5,000.0 | - |
| 118009 | Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 6,660.0 | 5,620.0 |
| 1181 | Газрын төлбөр | 6,465.3 | 16,170.5 |
| 118101 | Газрын төлбөр | 6,465.3 | 16,170.5 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 81,907.2 | 647,798.8 |
| 118202 | Ан амьтны нөөц ашигласны төлбөр | 81,907.2 | 647,798.8 |
| 1183 | Бусад татвар | 4,604.9 | 0.7 |
| 118301 | Бусад татвар | 4,604.9 | 0.7 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 151,543.6 | 198,342.8 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 151,543.6 | 198,342.8 |
| 120003 | Торгуулийн орлого | 16,083.0 | 26,789.8 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 135,460.6 | 171,553.0 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 135,120.6 | 170,933.0 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 340.0 | 620.0 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,992,993.6 | 265,021.2 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,073,732.1 | 18,363.0 |
| 131003 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 18,363.0 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,073,732.1 | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 203,326.9 | 72,324.4 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 93,068.1 | 52,089.6 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 12,083.8 | 20,234.8 |
| 131107 | Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого | 98,175.0 | - |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 691,981.1 | 174,333.8 |
| 132006 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/ | 600,804.7 | - |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 91,176.4 | 174,333.8 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 23,953.5 | - |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 23,953.5 | - |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,061,279.7 | 1,580,321.4 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,061,279.7 | 1,580,321.4 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,003,455.0 | 1,298,838.2 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,115,198.0 | 376,016.2 |
| 210101 | Үндсэн цалин | 883,193.0 | 270,191.7 |
| 210102 | Нэмэгдэл | 154,136.5 | - |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,435.7 | - |
| 210104 | Урамшуулал | 73,432.9 | 2,091.8 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | 103,732.8 |

Баян-Овоо сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|-------------|---|------------------|------------------|
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 141,762.5 | 44,705.3 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 105,434.1 | 30,829.6 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,208.5 | 3,590.7 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,132.3 | 2,701.5 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,932.1 | 737.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 18,055.5 | 6,846.4 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 274,931.7 | 352,146.1 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 24,092.3 | 26,666.6 |
| 210302 | Түлш, халаалт | 250,492.6 | 321,621.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 346.7 | 3,858.5 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 85,680.8 | 59,083.6 |
| 210401 | Бичиг хэрэг | 11,242.6 | 6,254.2 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 51,541.7 | 36,900.5 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,574.4 | 1,193.5 |
| 210404 | Ном, хэвлэл | 974.9 | 50.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 9,080.0 | 10,040.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,267.3 | 4,645.4 |
| 2105 | Нормативт зардал | 101,749.0 | - |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 24,751.4 | - |
| 210502 | Хоол, хүнс | 57,724.0 | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 19,273.6 | - |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 7,236.1 | 7,310.2 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,736.0 | 4,810.2 |
| 210602 | Тавилга | 39.9 | - |
| 210604 | Урсгал засвар | 5,460.2 | 2,500.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 6,532.0 | 7,529.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,532.0 | 7,529.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 183,502.5 | 74,626.3 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 177,827.3 | 67,482.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,300.0 | 750.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 558.7 | 810.7 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 495.0 | 1,192.7 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 40.0 | 256.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,053.1 | 3,564.0 |
| 210807 | Газрын төлбөр | 228.4 | 571.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 86,862.4 | 377,421.4 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 83,535.5 | 350,031.2 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,326.9 | 27,390.2 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 57,824.6 | 281,483.2 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 44,136.3 | 20,401.0 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 11,638.6 | 18,601.0 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 14,292.6 | - |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 13,949.9 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,255.2 | 1,800.0 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 509.3 | 19,725.0 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 18,363.0 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 509.3 | 1,362.0 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 13,179.1 | 241,357.2 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 13,179.1 | - |
| 213505 | Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт | - | 241,357.2 |

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|--------|---|-------------|-------------|
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 219,658.6 | 789,001.2 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 178,973.2 | 576,572.2 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 178,973.2 | 576,572.2 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 178,973.2 | 576,572.2 |
| 220001 | Барилга байгууламж | 145,494.1 | 518,663.2 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 33,479.1 | 57,909.0 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (178,973.2) | (576,572.2) |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 40,685.4 | 212,429.0 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 73,719.8 | 114,405.2 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 114,405.2 | 326,834.2 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| /мянган төгрөгөөр/ | | | | | |
|--------------------|--|-------------|-------------|-----------|-------|
| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,065,922.9 | 1,824,848.9 | 241,074.0 | 88.3 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,407,100.6 | 1,306,185.7 | 100,914.9 | 92.8 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,386,399.6 | 1,285,784.7 | 100,614.9 | 92.7 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 396,041.0 | 376,016.2 | 20,024.8 | 94.9 |
| 210101 | Үндсэн цалин | 271,761.3 | 270,191.7 | 1,569.6 | 99.4 |
| 210104 | Урамшуулал | 2,100.0 | 2,091.8 | 8.2 | 99.6 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 122,179.7 | 103,732.8 | 18,446.9 | 84.9 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 45,694.6 | 44,705.3 | 989.3 | 97.8 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 31,072.5 | 30,829.6 | 242.9 | 99.2 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,655.6 | 3,590.7 | 64.9 | 98.2 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,924.4 | 2,701.5 | 222.9 | 92.4 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 731.2 | 737.0 | (5.8) | 100.8 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,310.9 | 6,846.4 | 464.5 | 93.6 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 365,033.5 | 352,146.1 | 12,887.4 | 96.5 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 33,061.1 | 26,666.6 | 6,394.5 | 80.7 |
| 210302 | Түлш, халаалт | 325,172.4 | 321,621.0 | 3,551.4 | 98.9 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,800.0 | 3,858.5 | 2,941.5 | 56.7 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 67,434.4 | 59,083.6 | 8,350.8 | 87.6 |
| 210401 | Бичиг хэрэг | 7,431.4 | 6,254.2 | 1,177.2 | 84.2 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 42,692.3 | 36,900.5 | 5,791.8 | 86.4 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,555.7 | 1,193.5 | 1,362.2 | 46.7 |
| 210404 | Ном, хэвлэл | 50.0 | 50.0 | - | 100.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 5,160.0 | 10,040.0 | (4,880.0) | 194.6 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 9,545.0 | 4,645.4 | 4,899.6 | 48.7 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 12,000.0 | 11,994.2 | 5.8 | 100.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 9,500.0 | 9,494.2 | 5.8 | 99.9 |
| 210604 | Урсгал засвар | 2,500.0 | 2,500.0 | - | 100.0 |
| 2107 | Томиллолт, зочны зардал | 8,780.0 | 7,529.0 | 1,251.0 | 85.8 |
| 210702 | Дотоод албан томиллолт | 8,780.0 | 7,529.0 | 1,251.0 | 85.8 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 9,585.7 | 8,663.9 | 921.8 | 90.4 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,000.5 | 1,519.5 | 481.0 | 76.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 750.0 | 750.0 | - | 100.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 950.0 | 810.7 | 139.3 | 85.3 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,272.2 | 1,192.7 | 79.5 | 93.8 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 289.0 | 256.0 | 33.0 | 88.6 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,564.0 | 3,564.0 | - | 100.0 |
| 210807 | Газрын төлбөр | 760.0 | 571.0 | 189.0 | 75.1 |

Баян-Овоо сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|-------------|--|--------------------|--------------------|-------------------|--------------|
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 481,830.4 | 425,646.4 | 56,184.1 | 88.3 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 454,430.4 | 398,256.2 | 56,174.3 | 87.6 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 27,400.0 | 27,390.2 | 9.8 | 100.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 20,701.0 | 20,401.0 | 300.0 | 98.6 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 20,701.0 | 20,401.0 | 300.0 | 98.6 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 18,601.0 | 18,601.0 | - | 100.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,100.0 | 1,800.0 | 300.0 | 85.7 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 658,822.3 | 518,663.2 | 140,159.1 | 78.7 |
| 220001 | Барилга байгууламж | 658,822.3 | 518,663.2 | 140,159.1 | 78.7 |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 2,160,461.3 | 1,832,388.6 | 328,072.7 | 84.8 |
| 31 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 175,297.9 | - | 175,297.9 | - |
| 310004 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | 175,297.9 | - | 175,297.9 | - |
| 32 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,619,109.7 | 1,660,835.6 | (41,725.9) | 102.6 |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 1,619,109.7 | 1,486,501.8 | 132,607.9 | 91.8 |
| 320002 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | - | 174,333.8 | (174,333.8) | #DIV/0! |
| 35 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 366,053.7 | 171,553.0 | 194,500.7 | 46.9 |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 260,707.0 | 170,933.0 | 89,774.0 | 65.6 |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,000.0 | 620.0 | 380.0 | 62.0 |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 104,346.7 | - | 104,346.7 | - |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□ | - | 104,346.7 | (104,346.7) | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□ | - | 111,886.5 | (111,886.5) | |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | 52 | 52 | 0 | 100 |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 2 | 2 | 0 | 100 |
| 610001 | Төсвийн байгууллага | 2 | 2 | 0 | 100 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 25 | 25 | 0 | 100 |
| 620001 | Удирдах ажилтан | 9 | 9 | 0 | 100 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 9 | 9 | 0 | 100 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 4 | 4 | 0 | 100 |
| 620004 | Гэрээт ажилтан | 3 | 3 | 0 | 100 |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 25 | 25 | 0 | 100 |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 10 | 10 | 0 | 100 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 5 | 5 | 0 | 100 |
| 650010 | Гэрээт ажилтан | 3 | 3 | 0 | 100 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 7 | 7 | 0 | 100 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Тайлант он |
|-------------|--|-----------------|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 72,324.4 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 72,324.4 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 70,962.5 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 70,962.5 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 70,962.5 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,362.0 |
| 2133 | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | 1,362.0 |
| 213405 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 1,362.0 |
| I | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 72,324.4 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 72,324.4 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 52,089.6 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 20,234.8 |

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баян-Овоо сум нь “Хүний хөгжил, уламжлалт ёс заншлаа дээдлэн, дэд бүтэц, жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ, аялал жуулчлал хөгжсөн эдийн засгийн өсөлтийг тогтворжуулж, экологийн тэнцвэрт байдлыг хадгалан, хөдөө аж ахуйн салбарын хөгжлөөр тэргүүлэгч сум болно” гэсэн эрхэм зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааныхаа зорилтыг тодорхойлжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баян-Овоо сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь 2018 онд аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсээс гаргасан "Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баян-Овоо сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,708,186.0 мянган төгрөгөөр буюу 58.7 хувиар буурсан байна.

Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | | Эцсийн үлдэгдэл | | Өөрчлөлт | |
|---|--------------------|---------------|--------------------|---------------|----------------------|---------------|
| | Дүн | Эзлэх хувь | Дүн | Эзлэх хувь | Дүн | Хувь |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 524,409.2 | 8.3% | 861,250.6 | 33.1% | 336,841.4 | 64.2% |
| Мөнгөн хөрөнгө | 114,405.2 | 1.8% | 326,834.2 | 12.5% | 212,429.0 | 185.7% |
| Авлага | 224,073.5 | 3.5% | 261,212.3 | 10.0% | 37,138.8 | 16.6% |
| Урьдчилгаа | - | 0.0% | - | 0.0% | - | 0.0% |
| Бараа материал | 185,930.6 | 2.9% | 273,204.1 | 10.5% | 87,273.6 | 46.9% |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 5,789,319.8 | 91.7% | 1,744,292.3 | 66.9% | (4,045,027.4) | -69.9% |
| Үндсэн хөрөнгө | 7,508,018.8 | 118.9% | 2,591,385.1 | 99.5% | (4,916,633.8) | -65.5% |
| Хуримтлагдсан элэгдэл | (1,718,699.1) | -27.2% | (847,092.7) | -32.5% | 871,606.3 | -50.7% |
| Нийт хөрөнгө | 6,313,729.0 | 100.0% | 2,605,543.0 | 100.0% | (3,708,186.0) | -58.7% |
| Өр төлбөр | 39,892.5 | 0.6% | 80,063.7 | 3.1% | 40,171.2 | 100.7% |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 6,273,836.5 | 99.4% | 2,525,479.3 | 96.9% | (3,748,357.2) | -59.7% |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 6,313,729.0 | 100.0% | 2,605,543.0 | 100.0% | (3,708,186.0) | -58.7% |

Баян-Овоо сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн данс байна.

Эргэлтийн бус хөрөнгийн дүн өмнөх оноос 4,045,027.4 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн шинэчлэлтэй холбоотойгоор эрүүл мэндийн төв, сургууль, цэцэрлэг, соёлын төвийн хөрөнгийг орон нутгаас улсын төсөвт шилжүүлэн бүртгэсэнтэй холбоотой байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 326,834.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 212,429.0 мянган төгрөгөөр өссөн байна.

2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|------------------|------------------|------------------------|-----------------|
| Төрийн сангийн дансанд байгаа бэлэн мөнгө | 114,405.2 | 326,834.2 | 212,429.0 | 100.0 |
| Дүн | 114,405.2 | 326,834.2 | 212,429.0 | 100.0 |

Баян-Овоо сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 326,834.2 мянган төгрөг нь Орон нутгийн хөгжлийн сангийн дансанд 97,995.0 мянга, Хоршоог хөгжүүлэх сангийн дансанд 13,891.4 мянга, орон нутгийн ерөнхий орлогын дансанд 214,947.7 мянган төгрөг байршиж байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 261,212.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 37,138.8 мянган төгрөгөөр өссөн байна.

3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---------------------------------|------------------|------------------|------------------------|-----------------|
| Ажиллагчидтай холбогдсон авлага | 14.9 | 69,115.3 | 69,100.4 | 26.5 |
| Татаас, санхүүжилтийн авлага | 110,710.0 | - | (110,710.0) | - |
| Байгууллагаас авах авлага | 250.0 | 116.4 | (133.6) | 0.0 |
| Хувь хүмүүсээс авах авлага | 33,890.0 | 33,890.0 | - | 13.0 |
| Зээлийн авлага | 79,208.6 | 158,090.6 | 78,882.0 | 60.5 |
| Дүн | 224,073.5 | 261,212.3 | 37,138.8 | 100.0 |

Баян-Овоо сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Тайлант онд авлага дансны үлдэгдэл өссөн шалтгаан нь өмнөх онд сумын Эрүүл мэндийн төв нь ЭМД-ын сангаас авах санхүүжилтийн авлага болох 110,239.0 мянган төгрөгийг хүлээн авч барагдуулж, хоршоо хөгжүүлэх сангаас 2022 онд 100,000.0 мянган төгрөгийн зээл олгож авлагаар тусгасантай холбоотой байна.

| Авлагын үлдэгдэл /байгууллагаар/ | | /мянган төгрөгөөр/ | | |
|----------------------------------|------------------|--------------------|------------------------|-----------------|
| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
| Иргэдийн төлөөлөгчдийн хурал | - | 24.6 | 24.6 | 0.0 |
| Засаг даргын тамгын газар | - | 3,207.1 | 3,207.1 | 1.2 |
| Орон нутгийн хөгжлийн сан | 34,140.0 | 99,890.0 | 65,750.0 | 38.2 |
| Хоршоо хөгжүүлэх сан | 79,208.6 | 158,090.6 | 78,882.0 | 60.5 |
| Эмнэлэг | 110,710.0 | - | (110,710.0) | - |
| Цэцэрлэг | 14.9 | - | (14.9) | - |
| НИЙТ ДҮН | 224,073.5 | 261,212.3 | 37,138.8 | 100.0 |

Баян-Овоо сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Нийт авлагын 60.5 хувь буюу 78,882.0 мянган төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангийн авлага, 38.2 хувь 65,750.0 мянган төгрөг нь Орон нутгийн хөгжлийн сангийн авлага, 1.2 буюу 3,231.7 мянган төгрөг нь сумын ЗДТГ, ИТХ-ын ажиллагсадтай холбоотой холбоотой авлага байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 273,204.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 87,273.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

| 5. Бараа материалын үлдэгдэл | | / мянган төгрөгөөр/ | | |
|------------------------------|------------------|---------------------|------------------------|-----------------|
| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
| Тусгай зориулалтын материал | 32,813.4 | 4,897.2 | (27,916.1) | 1.8 |
| Эм боох материал | 19,548.2 | - | (19,548.2) | - |
| Дуусаагүй үйлдвэрлэл | - | 150,000.0 | 150,000.0 | 54.9 |
| Бэлэн бүтээгдэхүүн | 123.0 | - | (123.0) | - |
| Бичиг хэргийн материал | 7,052.3 | 2,615.1 | (4,437.2) | 1.0 |
| Аж ахуйн материал | 49,479.6 | 72,158.5 | 22,678.9 | 26.4 |
| Сэлбэг хэрэгсэл | 1,005.0 | 10,815.2 | 9,810.2 | 4.0 |
| Түлш, шатах тослох материал | 3,053.1 | 1,747.3 | (1,305.8) | 0.6 |
| Барилгын засварын материал | 1,411.5 | 1,005.5 | (406.0) | 0.4 |
| Хүнсний материал | 2,486.6 | 345.0 | (2,141.6) | 0.1 |
| Бусад хангамжийн материал | 58,957.9 | 19,620.3 | (39,337.6) | 7.2 |
| Нөөцийн бараа | 10,000.0 | 10,000.0 | - | 3.7 |
| Дүн | 185,930.6 | 273,204.1 | 87,273.6 | 100.0 |

Баян-Овоо сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл 273,204.1 мянган төгрөг болж өмнөх оноос 87,273.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Эрүүл мэндийн төв 16,857.0 мянга, Ерөнхий боловсролын сургууль 66,320.0 мянга, Цэцэрлэг 37,301.6 мянга, Соёлын төвийн 3,169.5 мянга, нийт 123,648.1 мянган төгрөгийн хөрөнгийг орон нутгаас улсын төсөвт шилжүүлж буурсан ч сумын "Байгалийн музей болон орон нутаг судлах танхимын барилга"-ын ажлын санхүүжилтэд ЗДТГ-ын байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 150,000.0 төгрөгийн санхүүжилтийг олгож ажил дуусаагүй тул ЗДТГ-ын эргэлтийн хөрөнгөд бүртгэсэн нь голлох нөлөө үзүүлж байна.

| Бараа материалын үлдэгдэл байгууллагаар | | /мянган төгрөгөөр/ | | |
|---|----------------|--------------------|------------------------|-----------------|
| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
| Иргэдийн төлөөлөгчдийн хурал | 4,583.3 | 13,012.1 | 8,428.9 | 4.8 |
| Засаг даргын тамгын газар | 47,699.2 | 250,192.0 | 202,492.8 | 91.6 |
| Орон нутгийн хөгжлийн сан | 10,000.0 | 10,000.0 | - | 3.7 |
| Хоршоо хөгжүүлэх сан | - | - | - | - |
| Эмнэлэг | 16,857.0 | - | (16,857.0) | - |

| | | | | |
|-----------------|------------------|------------------|-----------------|--------------|
| Соёлын төв | 3,169.5 | - | (3,169.5) | - |
| Сургууль | 66,320.0 | - | (66,320.0) | - |
| Цэцэрлэг | 37,301.6 | - | (37,301.6) | - |
| НИЙТ ДҮН | 185,930.6 | 273,204.1 | 87,273.6 | 100.0 |

Баян-Овоо сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 2,591,385.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 4,916,633.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|-------------------------------|--------------------|--------------------|------------------------|-----------------|
| БИЕТ ХӨРӨНГӨ | 7,396,840.8 | 2,462,127.1 | (4,934,713.8) | 95.0 |
| Барилга байгууламж, орон сууц | 5,657,367.3 | 1,413,871.9 | (4,243,495.4) | 54.6 |
| Тээврийн хэрэгсэл | 485,654.8 | 398,963.8 | (86,691.0) | 15.4 |
| Машин тоног төхөөрөмж | 722,907.4 | 330,315.2 | (392,592.2) | 12.7 |
| Тавилга эд хогшил | 284,578.9 | 72,299.8 | (212,279.1) | 2.8 |
| Дуусаагүй барилга, байгууламж | 5,800.0 | 5,800.0 | - | 0.2 |
| Номын фонд | 12,229.8 | - | (12,229.8) | - |
| Бусад үндсэн хөрөнгө | 228,302.6 | 240,876.4 | 12,573.7 | 9.3 |
| БИЕТ БУС ХӨРӨНГӨ | 111,178.0 | 129,258.0 | 18,080.0 | 5.0 |
| Программ хангамж | 3,950.0 | 780.0 | (3,170.0) | 0.0 |
| Бусад биет бус хөрөнгө | 107,228.0 | 128,478.0 | 21,250.0 | 5.0 |
| НИЙТ ДҮН | 7,508,018.8 | 2,591,385.1 | (4,916,633.8) | 100.0 |

Баян-Овоо сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,591,385.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 4,916,633.8 мянган төгрөгөөр буурсан нь Эрүүл мэндийн төв 614,989.8 мянга, Соёлын төвийн 915,979.1 мянга, Боловсрол шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газар байгуулагдсантай холбоотойгоор Ерөнхий боловсролын сургууль 3,312,527.7 мянга, Цэцэрлэг 170,933.5 мянга нийт 5,014,430.1 мянган төгрөгийн хөрөнгийг орон нутгаас улсын төсөвт шилжүүлэн бүртгэсэн нь голлох нөлөө үзүүлж байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|------------------------------|--------------------|--------------------|------------------------|-----------------|
| Засаг даргын тамгын газар | 93,025.5 | 25,025.5 | (68,000.0) | 1.0 |
| Иргэдийн төлөөлөгчдийн хурал | 2,400,563.2 | 2,566,359.6 | 165,796.4 | 99.0 |
| Эмнэлэг | 614,989.8 | - | (614,989.8) | - |
| Соёлын төв | 915,979.1 | - | (915,979.1) | - |
| Сургууль | 3,312,527.7 | - | (3,312,527.7) | - |
| Цэцэрлэг | 170,933.5 | - | (170,933.5) | - |
| НИЙТ ДҮН | 7,508,018.8 | 2,591,385.1 | (4,916,633.8) | 100.0 |

Баян-Овоо сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Тайлант онд нэмэгдсэн 203,039.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн 57,909.0 мянган төгрөгийн хөрөнгө төсвийн хөрөнгөөр худалдан авч, 52,579.8 мянган төгрөгийн хөрөнгө хандив тусламжаар, 92,551.1 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлэн авч бүртгэсэн байна.

9. Үндсэн хөрөнгийн орлого, зарлагын төрөл

/мянган төгрөгөөр/

| Нэмэгдсэн | 203,039.9 | Хасагдсан | 5,119,673.6 |
|-----------------|-----------|------------|-------------|
| Худалдан авсан | 57,909.0 | Худалдсан | - |
| Хандиваар | 52,579.8 | Акталсан | 105,243.5 |
| Шилжүүлэн авсан | 6,524.0 | Шилжүүлсэн | 5,014,430.1 |
| Бусад | 86,027.1 | Бусад | - |

Баян-Овоо сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 80,063.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 40,171.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 10. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|--------------------------------------|-----------------|-----------------|------------------------|-----------------|
| БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР ДҮН | 39,892.5 | 80,063.7 | 40,171.2 | 100.0 |
| Ажилчидтай холбогдсон өглөг | 3.0 | - | (3.0) | - |
| Бараа, үйлчилгээний зардлын өглөг | 34,289.1 | 360.0 | (33,929.1) | 0.4 |
| Байгууллагад төлөх өглөг | 5,600.4 | 79,101.9 | 73,501.5 | 98.8 |
| Хувь хүмүүст төлөх өглөг | - | 601.8 | 601.8 | 0.8 |
| Дүн | 39,892.5 | 80,063.7 | 40,171.2 | 100.0 |

Богино хугацаат өр төлбөр нь 80,063.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд ЗДТГ-ын бараа үйлчилгээний өглөг 360.0 мянга, ИТХ-ын байгууллагад өгөх өглөг 2,710.0 мянга, Хувь хүмүүст өгөх 601.8 мянга, Орон нутгийн хөгжлийн сангийн 76,391.9 мянган төгрөгийн байгууллагад төлөх өглөг байна.

Өгөлтийн дансны үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|------------------------------|-----------------|-----------------|------------------------|-----------------|
| Иргэдийн төлөөлөгчдийн хурал | 1,358.4 | 3,311.8 | 1,953.4 | 4.1 |
| Засаг даргын Тамгын газар | 18,701.0 | 360.0 | (18,341.0) | 0.4 |
| Орон нутгийн хөгжлийн сан | 2,997.6 | 76,391.9 | 73,394.3 | 95.4 |
| Эмнэлэг | 16,376.6 | - | (16,376.6) | - |
| Соёлын төв | 50.0 | - | (50.0) | - |
| Сургууль | 249.0 | - | (249.0) | - |
| Цэцэрлэг | 160.0 | - | (160.0) | - |
| НИЙТ ДҮН | 39,892.5 | 80,063.7 | 40,171.2 | 100.0 |

Баян-Овоо сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 2,525,479.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 3,748,357.2 мянган төгрөгөөр буурсан байна.

11. Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өссөн+ Буурсан - | Дүнд эзлэх хувь |
|---|--------------------|--------------------|----------------------|-----------------|
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,368,520.2 | 530,810.9 | (837,709.4) | 21.0 |
| Өмч: - төрийн | 1,368,520.2 | 530,810.9 | (837,709.4) | 21.0 |
| Хуримтлагдсан үр дүн | 3,674,480.0 | 1,694,822.1 | (1,979,658.0) | 67.1 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,230,836.2 | 299,846.3 | (930,989.9) | 11.9 |
| Дүн | 6,273,836.5 | 2,525,479.3 | (3,748,357.2) | 100.0 |

Баян-Овоо сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл үлдэгдэл 2,525,479.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 3,748,357.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 1,979,658.0 мянга, Сургууль, Цэцэрлэг, Соёлын төвийн хөрөнгө улсын төсөвт шилжсэнтэй холбоотой 1,768,699.3 мянган төгрөгийн өөрчлөлттэй холбоотой байна.

3.5.11 Орлогын данс

Сумын ИТХ-ын 2021.12.20-ний өдрийн хуралдаанаар 02/02 дугаар тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 1,785,870.0 мянга, хүү торгуулийн орлогыг 13,000.0 мянга, нийт 1,798,870.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Сумын төсвийн тодотголыг ИТХ-ын 2022.06.27-ны өдрийн 06/06 дугаар тогтоолоор татварын орлогыг 1,742,870.0 мянга, хүү торгуулийн орлогыг 13,000.0 мянга, нийт 1,755,870.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Засварааны газрын хувь оролцоо

/мянган төгрөгөөр/

| Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|--------------------|--------------------|------------------|--------------|
| 1.Татварын орлого | 1,742,870.0 | 1,905,957.8 | 163,087.8 | 109.4 |
| 1.10. ЦХТАО /суутган-1/ | 945,000.0 | 991,899.8 | 46,899.8 | 105.0 |
| 1.1.ИОТХ | 35,000.0 | 120,736.6 | 85,736.6 | 345.0 |
| 1.2. Хадгаламжийн хүүгийн орлого | 10,000.0 | 5,427.6 | (4,572.4) | 54.3 |
| 1.3. Үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны албан татвар | 3,000.0 | 80.0 | (2,920.0) | 2.7 |
| 1.4.Бууны татвар | 870.0 | 660.0 | (210.0) | 75.9 |
| 1.5.Улсын тэмдэгтийн хураамж | 1,500.0 | 1,425.8 | (74.2) | 95.1 |
| 1.6. Газрын төлбөр | 21,000.0 | 16,170.5 | (4,829.5) | 77.0 |
| 1.7.Ан агнуурын нөөц ашигласны төлбөр | 540,000.0 | 647,798.8 | 107,798.8 | 120.0 |
| 1.8. Хог хаягдлын үйлчилгээний төлбөр | 6,000.0 | 5,620.0 | (380.0) | 93.7 |
| 1.9. ТТАМАТөлбөр | 5,000.0 | - | (5,000.0) | - |
| 1.11. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар | 25,500.0 | 25,295.3 | (204.7) | 99.2 |
| 1.12. Малын тоо толгойн албан татвар | 150,000.0 | 90,843.4 | (59,156.6) | 60.6 |
| 2.Татварын бус орлого | 13,000.0 | 26,789.8 | 7,120.0 | 206.1 |
| 2.1.Хүү торгуулийн орлого | 13,000.0 | 26,789.8 | 7,120.0 | 206.1 |
| Нийт дүн | 1,755,870.0 | 1,932,747.6 | 170,207.8 | 110.1 |

Баян-Овоо сумын ИТХ-ын тогтоол

Сумын төсөвт төвлөрөх орлогыг 170,207.8 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн ба үүнд цалин, хөлс түүнтэй адилтгах орлогын татвар, ан агнуурын нөөц ашигласны төлбөрийн орлого биелсэн нь голлон нөлөөлсөн байна.

Орлогын нэр төрлөөр авч үзвэл түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлого огт ороогүй, хадгаламжийн хүү, үл хөдлөх борлуулсны, буу, малын тоо, толгой, үл хөдлөх хөрөнгийн албан татвар, улсын тэмдэгтийн хураамж, хог хаягдлын үйлчилгээний төлбөр гэсэн орлогын нэр төрлүүдээр төлөвлөгөө биелээгүй байна.

3.5.12 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71506, 71702, 71801, 71802, 72101 гэсэн кодтой 8 хөтөлбөрт зориулан 2,065,922.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,824,848.9 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас 1,306,185.7 мянган төгрөгийг урсгал зардалд, 518,663.2 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 2 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021.12.20-ний өдрийн 02/02 дүгээр тогтоолоор нийт 2,190,198.9 мянган төгрөгийг анх баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2021.12.20-ны өдрийн 02/02 дугаар тогтоолоор анх 2,190,198.9 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2022.06.27-ний өдрийн 06/06 дугаар тогтоолоор 124,276.0 мянган төгрөгөө бууруулж 2,065,922.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Нийт зардлын 1,755,870.0 мянган төгрөгийг сумд төвлөрөх татварын болон татварын бус орлогоос, 175,297.9 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 261,707.0 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, 114,405.2 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс тус тус санхүүжүүлж аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг 241,357.2 мянган төгрөгөөр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр сумын төсөвт төвлөрүүлэх орлогыг 170,207.8 мянган төгрөгөөр давуулан биелүүлж, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас авах санхүүжилтийг 964.1 мянган төгрөгөөр дутуу санхүүжсэн ч аймгийн төсөвт төвлөрүүлэх 241,357.2 мянган төгрөгийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн байна.

14. Төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь | Төвлөрүүлсэн |
|------------------------------|--------------------|--------------------|------------------|-------------|-----------------|
| Засаг даргын Тамгын газар | 768,386.2 | 743,662.3 | 24,723.9 | 96.8 | 24,373.9 |
| Иргэдийн Төлөөлөгчдийн хурал | 121,077.4 | 118,714.9 | 2,362.5 | 98.0 | 2,362.5 |
| Соёлын төв | 44,537.6 | 38,611.6 | 5,926.0 | 86.7 | 5,926.0 |
| Хоршоо хөгжүүлэх сан | 155,565.4 | 100,100.0 | 55,465.4 | 64.3 | - |
| Сургууль | 183,841.9 | 180,011.1 | 3,830.8 | 97.9 | 3,830.8 |
| Цэцэрлэг | 94,538.4 | 88,646.7 | 5,891.7 | 93.8 | 5,891.7 |
| Эрүүл мэндийн төв | 39,153.7 | 36,439.2 | 2,714.5 | 93.1 | 2,714.5 |
| Орон нутгийн хөгжлийн сан | 658,822.3 | 518,663.2 | 140,159.1 | 78.7 | - |
| Нийт дүн | 2,065,922.9 | 1,824,848.9 | 241,074.0 | 88.3 | 45,099.5 |

Баян-Овоо сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл мянган төгрөг буюу 88.3 хувьтай байгаа нь ЗДТГ-ын төсвийг 24,723.9 мянга, ИТХ-ын төсвийг 2,362.5 мянга, Ерөнхий боловсролын сургууль 3,830.8 мянга, сургуулийн өмнөх боловсрол 5,891.7 мянга, Эрүүл мэндийн төв 2,714.5 мянга, Соёлын төв 3,338.3 мянган төгрөгөөр тогтмол зардлыг тус тус хэмнэж орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний зардлыг 140,159.1 мянган төгрөгөөр дутуу санхүүжүүлж, хоршоо хөгжүүлэх сангаас олгох зээлийг 55,465.4 мянган төгрөгөөр дутуу олгосонтой холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 1,300.0 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогоор 36,812.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 28,862.9 мянган төгрөгийг зарцуулж 9,249.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | ИТХ | ЗДТГ | НИЙТ |
|----------|-----|------|------|
|----------|-----|------|------|

Баян-Овоо сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | |
|--|-----------------|----------------|-----------------|
| НИЙТ ОРЛОГО | 71,024.4 | 1,300.0 | 72,324.4 |
| Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 50,789.6 | 1,300.0 | 52,089.6 |
| Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 20,234.8 | - | 20,234.8 |
| НИЙТ ЗАРЛАГА | 70,962.5 | 1,300.0 | 72,262.5 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 70,962.5 | 1,300.0 | 72,262.5 |
| Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | - | - |
| Хөрөнгийн санхүүжилт | - | - | - |
| Төсөвт төвлөрүүлсэн | 62.0 | - | 62.0 |

Баян-Овоо сумын санхүүгийн нэгтгэсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Аудитын гол асуудал

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Баян-Овоо сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 2 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 4 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Төрийн аудитын байгууллагаас Баян-Овоо сумын Засаг даргын харьяа байгууллагад аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Төсвийн шүүд захирагчийн аудитын дүн

| Байгууллагын нэр | Байгууллагын тоо | | | |
|---------------------|------------------|------------|---------------------------------------|--------------------|
| | Хамрагдвал зохих | Хамрагдсан | Гүйцэтгэсэн Бие дааж дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан |
| ЗДТГ | 1 | 1 | | 1 |
| ИТХ | 1 | 1 | | 1 |
| ОНХС | 1 | 1 | | 1 |
| ХХС | 1 | 1 | | 1 |
| НИЙТ ЗАРЛАГА | 4 | 4 | | 4 |

Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

Сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 4 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагыг түүвэрт хамруулсан.

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 67,137.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрчээ. Хүснэгтээр харуулбал:

Төсвийн шүүд захирагчийн алдаа зөрчлийн дүн

| Байгууллагын нэр | Нийт алдаа зөрчлийн дүн | | Залруулга | | Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт | | | | | |
|--|-------------------------|----------------|-----------|----------|---|--------------|-----------------------|-----------------|---------------|--------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тогтоосон төлбөрийн акт | | Өгсөн албан шаардлага | | Өгсөн зөвлөмж | |
| | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн зөрчил | | | | | | | | | | |
| ЗДТГ | 4 | 67137.8 | | | 1 | 572.8 | 1 | 65,945.0 | 2 | 620.0 |
| | 4 | 67137.8 | | | 1 | 572.8 | 1 | 65,945.0 | 2 | 620.0 |
| СТА-аар шалгасан нийцлийн аудитын асуудал | | | | | | | | | | |
| ЗДТГ | 2 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 2 | 0 | 0 | 0 |
| | 2 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 2 | 0 | 0 | 0 |
| Нийт дүн | 6 | 67137.8 | | | 1 | 572.8 | 3 | 65,945.0 | 2 | 620.0 |

Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 8 хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр нийт 2,065,922.9 мянган төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр 1,824,848.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайлан хөтөлбөрөөр

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|--------------------|--------------------|------------------|-------------|
| НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,065,922.9 | 1,824,848.9 | 241,074.0 | 88.3 |
| 70105 ОН-ын өөрөө удирд ёсны байгуул | 121,077.4 | 118,714.9 | 2,362.5 | 98.0 |
| 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал | 106,701.6 | 104,361.1 | 2,340.5 | 97.8 |
| 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, | 700.0 | 700.0 | - | 100.0 |
| 80815 Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөг | 6,048.1 | 6,048.1 | - | 100.0 |
| 80825 Багийн ИНХ-ын даргын урамшуулал | 7,627.7 | 7,605.7 | 22.0 | 99.7 |
| 70106 ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага | 768,386.2 | 743,662.3 | 24,723.9 | 96.8 |
| 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал | 393,110.4 | 375,704.7 | 17,405.7 | 95.6 |
| 80106 Баг, хорооны үйл ажиллагааны зардал | 62,557.9 | 55,990.7 | 6,567.2 | 89.5 |
| 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, | 1,000.0 | 900.0 | 100.0 | 90.0 |
| 80815 Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөг | 12,552.9 | 12,552.9 | - | 100.0 |
| 81102 Орон нутгийн нөөц хөрөнгө | 66,000.0 | 65,945.0 | 55.0 | 99.9 |
| 81701 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх | 220,365.0 | 219,770.0 | 595.0 | 99.7 |
| 82212 Хур хог хаягдал, орчны бохирдлыг бууруулах | 4,800.0 | 4,800.0 | - | 100.0 |
| 82310 Гамшгаас сэргийлэх сургалт, сурталчилгаа | 8,000.0 | 7,999.0 | 1.0 | 100.0 |
| 70503 Орон нутгийн зорилгот хөрөнгө оруулалт | 658,822.3 | 518,663.2 | 140,159.1 | 78.7 |
| 80904 Нийгмийн зориулалттай барилга | 333,524.4 | 330,255.2 | 3,269.2 | 99.0 |
| 83401 ОНХС - Итгэлцүүрээр олгох | 86,977.1 | 36,847.8 | 50,129.3 | 42.4 |
| 83403 ОНХС - Ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр | 70,702.2 | 39,910.2 | 30,792.0 | 56.4 |
| 83405 ОНХС - Малын тоо толгойн албан татвар | 150,000.0 | 107,000.0 | 43,000.0 | 71.3 |
| 83406 ОНХС - Бусад | 17,618.6 | 4,650.0 | 12,968.6 | 26.4 |
| 71506 Суурин газрын усан хангамж | 39,153.7 | 36,439.2 | 2,714.5 | 93.1 |
| 80112 Нийтлэг үйлчилгээ | 39,153.7 | 36,439.2 | 2,714.5 | 93.1 |
| 71702 Соёл урлаг | 44,537.6 | 38,611.6 | 5,926.0 | 86.7 |
| 80112 Нийтлэг үйлчилгээ | 44,537.6 | 38,611.6 | 5,926.0 | 86.7 |
| 71801 Сургуулийн өмнөх боловсрол | 94,538.4 | 88,646.7 | 5,891.7 | 93.8 |
| 80112 Нийтлэг үйлчилгээ | 94,538.4 | 88,646.7 | 5,891.7 | 93.8 |
| 71802 Ерөнхий боловсрол | 183,841.9 | 180,011.1 | 3,830.8 | 97.9 |
| 80112 Нийтлэг үйлчилгээ | 183,841.9 | 180,011.1 | 3,830.8 | 97.9 |
| 72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих | 155,565.4 | 100,100.0 | 55,465.4 | 64.3 |
| 82611 Жижиг дунд үйлдвэрийг дэмжих | 155,565.4 | 100,100.0 | 55,465.4 | 64.3 |

Баян-Овоо сумын Засаг даргын нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баян-Овоо сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цээням, дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 05-ний өдрийн 10 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,953,650.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 29,304.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 20,513.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Баян-Овоо сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

Баян-Овоо сумын "Байгалийн музей болон орон нутаг судлах танхимын барилга"-ын 298,420.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлыг гүйцэтгүүлэхдээ сумын засаг дарга нь худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй "Гэгээн шавь" ХХК-тай шууд гэрээ байгуулан байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 150,000.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 683,822.3 мянган төгрөгийн 17 мэдээллийг байршуулаагүй байна.

4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.7.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд 2022 оны 3 дугаар улирлын байдлаар завсрын аудит хийсэн ба асуудлын бүртгэлийг танилцуулсан, жилийн эцсээр дүнг нэгтгэн танилцуулсан болно.

4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 62,525.8 мянган төгрөгийн 5 зөвлөмж хүргүүлсэн ба зөвлөмжийн хэрэгжилтийг сумын Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 30-ний өдрийн 110 тоот албан бичгээр ирүүлж хэрэгжилтийг тооцсон байна.

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж

/ мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Биелэгдээгүй | | Хэрэгжилтийн хувь |
|----------|---------------------|-----------------|----------|-----------------|--------------|----------|-------------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 5 | 62,525.8 | 5 | 62,525.8 | 0 | 0 | 100 |
| | 5 | 62,525.8 | 5 | 62,525.8 | 0 | 0 | 100 |

Шийдвэрийн хэрэгжилт

4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 160,538.4 мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

1. Орон нутгийн хөгжлийн сангаас олгосон 66,000.0 мянган төгрөгийн дутуу хэрэгжсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтийг ажиллагсадаас авах авлагаар бүртгэсэн.

2. Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн төсвийн төлөвлөгөөг нийт 94538.4 мянган төгрөгөөр зөрүүтэй нэгтгэсэн.

Аудитаар нийт 160,185.2 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 58,090.6 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 75,313.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

албан шаардлага өгч, 26,781.3 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

5.1.1. Тус сумын сум хөгжүүлэх сангаас зээл авсан 12 зээлдэгчийн 158,090.6 мянган төгрөгийн үлдэгдэл байгаагаас 10 зээлдэгчийн 58,090.6 мянган төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн ч хууль хяналтын байгууллагад шилжүүлээгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-ын 3.5.5-д " зээл, зээлийн хүүгийн орлогыг сангийн дансанд төвлөрүүлэх", 4.7. дахь "Иргэн, хуулийн этгээд авсан зээл, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаанд сангийн дансанд буцаан төлнө" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль тогтоомж, зээлийн гэрээний үүргээ зөрчиж, санд төвлөрүүлээгүй 58,090.6 мянган төгрөгийг зээлдэгчдээр төлүүлж, төлбөрийг Баян-Овоо сумын Сум хөгжүүлэх сангийн 100031655401 тоот дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

5.2 Албан шаардлага

5.2.1. Тус сумын Засаг даргын 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтын дагуу хөтөлбөр, арга хэмжээгээр гаргаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид Засаг даргын төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалттай нийцүүлэн тайлагнаж зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

5.2.2. Малын тоо толгойн албан татварын орлогоор тайлант онд 150,000.0 мянган төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөсөн ч 90,843.3 мянган төгрөг төвлөрүүлж 59,156.6 мянган төгрөг дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1. дэх "Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу ногдуулсан албан татварыг тэнцүү хоёр хуваан тухайн жилийн 7 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор өөрийн өмчилж байгаа малын тоо толгой тоологдож бүртгэгдсэн сум, дүүргийн төсөвт төлнө" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хуульд заасан хугацаанд төвлөрүүлээгүй малын тоо, толгойн албан татварын 59,156.6 мянган төгрөгийг орон нутгийн орлогод бүрэн төвлөрүүлж зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

5.2.3. Малын тоо толгойн албан татварын орлогоор тайлант онд 90,843.3 мянган төгрөг төвлөрсөн байхад орон нутгийн хөгжлийн санд 107,000.0 мянган төгрөг буюу 16,156.7 мянган төгрөг илүү хуваарилсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Татварын орлогын төрөл хооронд гүйлгэн зарцуулсан зөрчлийг арилган, ОНХС-гаас ОНО-ын дансанд 16,156.7 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлэх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

5.2.4. Тайлант онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст орон нутгийн хөгжлийн сан болон хоршоо хөгжүүлэх сангаас олгосон хөрөнгийн санхүүжилтийн зээлтэй холбоотой 683,822.3 мянган төгрөгийн 17 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэсэн заалтыг гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлээгүй мэдээллийг нөхөн байршуулж зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус сумын ОНХО-ын дансанд сумд төвлөрөх орон нутгийн орлогоор 1,932,747.6 мянган төгрөг төвлөрсөн ч Татварын хэлтэст 1,959,528.9 мянган төгрөг буюу 26,781.3 мянган төгрөгөөр илүү мэдээлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид орон нутгийн дансанд төвлөрсөн орлогын тайлан мэдээг Татварын хэлтэст үнэн зөв мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

| Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|-----------------------------|------------|------------------|-----------------------------------|-----|--------------------------|------------------|------------|------------------|--------------|-----|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Залруулсан | | Залруулаагүй | |
| | | | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Баян-Овоо сумын Засаг дарга | 2 | 160,538.4 | | | 2 | 160,538.4 | 2 | 160,538.4 | | |
| Дүн | 2 | 160,538.4 | | | 2 | 160,538.4 | 2 | 160,538.4 | | |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|-----------------------------|-------------|------------------|---------------|-----------------|-----------------|------------------|----------|-----------------|
| | Тоо | Дүн | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Баян-Овоо сумын Засаг дарга | 6 | 160,185.2 | 1 | 58,090.6 | 3 | 75,313.3 | 1 | 26,781.3 |
| Баян-Овоо сумын ЗДТГ | 4 | 67,137.8 | 1 | 572.8 | 1 | 65,945.0 | 2 | 620.0 |
| Дүн | 10 | 227,323.0 | 2 | 58,663.4 | 4 | 141,258.3 | 2 | 27,401.3 |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|-------------|----------|---------------|-----|-----------------|----------|---------|-----|
| | Тоо | Дүн | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Баян-Овоо сумын Засаг дарга | 1 | 0 | | | 1 | 0 | | |
| Баян-Овоо сумын ЗДТГ | | | | | 1 | 0 | | |
| Дүн | 1 | 0 | | | 2 | 0 | | |
| Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Баян-Овоо сумын ЗДТГ | 1 | 0 | | | 1 | 0 | | |
| Дүн | 1 | 0 | | | 1 | 0 | | |
| Нийт Дүн | 1 | 0 | | | 1 | 0 | | |

5. Хавсралт 1.: Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо | Аудитын нэр: | Баян-Овоо сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит | Аудитын код: | |
|------------------------------|--------------|---|--------------------|--|
| 2022 | | | БНА-2023/9/СТА-ТТЗ | |
| Шалгагдсан байгууллагын нэр: | | Баян-Овоо сумын Засаг дарга | Мянган төгрөг | |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|-----------------|---------------------------------------|---|-------------------------|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| Харьяа төсвийн байгууллагуудын дүн | | 67,137.8 | | | |
| Засаг даргын тамгын газар | | 67,137.8 | | | |
| Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл | | | | | |
| 1 | Тайлант хугацаанд тус байгууллагын архив бичиг хэргийн ажилтанд 540.4 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал илүү олгосон мөн цалингийн зардлаас ажилчдаас суутгасан сонин захиалгын үнэ 32.4 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн байна. | 572.8 | Төлбөрийн акт тогтоосон | Дарга, нягтлан бодогч | М.Жавзансүрэн, Л.Алимаа |
| 2 | Тус байгууллагын барилгын зэргэлдээ байрлах ХААН банкны өмчлөлийн барилгаас сар бүр халаалтын төлбөр авч төсөвт байгууллагын өөрийн орлогоор бүртгэж байна. | 620.0 | Зөвлөмж өгсөн | Дарга, нягтлан бодогч | М.Жавзансүрэн, Л.Алимаа |

Баян-Овоо сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|--|-----------------|---------------------------------------|---|-------------------------|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| 3 | Ажиллагсдын цалингаас тайлант хугацаанд хамтын сан, бэлэг, хандив зэргээр нийт 16781.5 мянган төгрөгийг суутгасан нь Хөдөлмөрийн тухай хуулийн 119.1 дэх заалтыг зөрчсөн байна. | - | Зөвлөмж өгсөн | Дарга, нягтлан бодогч | М.Жавзансүрэн, Л.Алимаа |
| 4 | Тус сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс тайлант онд нийт 65945.0 мянган төгрөгийг зарцуулсан ч зарцуулалтын тайлан, захирамжийн хэрэгжилтийг Засаг даргын зөвлөлд тайлагнаагүй байна. | 95,945.0 | Албан шаардлага | Дарга, нягтлан бодогч | М.Жавзансүрэн, Л.Алимаа |
| | Дүн | 67,137.8 | | | |
| Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | | | | | |
| 1 | Баян-Овоо сумын "Байгалийн музей болон орон нутаг судлах танхимын барилга"-ын 298,420.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлыг гүйцэтгүүлдээ сумын засаг дарга нь худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй "Гэгээн шавь" ХХК-тай шууд гэрээ байгуулан байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 150,000.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон. | 0 | Албан шаардлага | Дарга, нягтлан бодогч | М.Жавзансүрэн, Л.Алимаа |
| 2 | Тайлант хугацаанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 249,127.5 мянган төгрөгийн 6 гүйлгээ, 153,404.3 мянган төгрөгийн 8 зарлагын гүйлгээг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлээгүй. | 0 | Албан шаардлага | Дарга, нягтлан бодогч | М.Жавзансүрэн, Л.Алимаа |
| | Дүн | 0 | | | |

__оОо__